



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/656

Булган сум

**Англи хэлний сургалт зохион байгуулахад  
хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа; нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, 2025 оны VI дугаар хуралдааны “Англи хэлтэй Булган хөтөлбөр батлах тухай” VI/33 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Англи хэлтэй Булган” хөтөлбөрт заасан англи хэлний багш нарыг чадавхжуулах, мэргэшүүлэх, олон улсын зэрэгтэй болгох зорилтын хүрээнд “Монголын Англи хэлний академи”-тай хамтран зохион байгуулах сургалтын удирдамжийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Англи хэлний сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Боловсролын газрын дарга (Ц.Цолмонбаатар)-д үүрэг болгосугай.

3.Сургалтад зарцуулагдах 6,540,000 (зургаан сая таван зуун дөчин мянга) төгрөгийг “Англи хэлтэй Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010913

Аймгийн Засаг даргын 2025 оны  
10 дугаар сарын 15-ны өдрийн  
А/656 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН АНГЛИ ХЭЛНИЙ БАГШ,  
АХЛАХ АНГИЙН СУРАГЧДЫН АНГЛИ ХЭЛНИЙ ТҮВШИНГ АХИУЛАХ,  
ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

**Зорилго:**

“Англи хэлтэй Булган” хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш, ахлах ангийн сурагчдын гадаад хэлний онолын мэдлэг чадвар, арга зүйг сайжруулах, олон улсын шалгалт IELTS, TOEFL-ын оноотой болоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах.

**Зохион байгуулалт:**

Хугацаа: 2025 оны 10-р сарын 20-24-ний өдрүүдэд 09:00-18:00 цагт

Хаана: Булган сумын ЕБС-ын 3 дугаар сургуульд

Хамрах хүрээ: Булган аймгийн ЕБС-ын англи хэлний 67 багш, ахлах ангийн 42 сурагч

**Зохион байгуулагч:**

- Булган аймгийн Засаг даргын тамгын газар,
- Боловсролын газар
- Монголын англи хэлний академийн сургагч багш нар

**Хүрэх үр дүн:**

1. Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш нарыг онолын мэдлэг, ур чадвар, арга зүй сайжирч, олон улсын шалгалт IELTS, TOEFL-ын оноотой болох арга зүйг эзэмшсэн байна.

2. Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын англи хэлний ур чадвараа сайжруулах, олон улсын шалгалт IELTS, TOEFL-ын оноо аргачлалд суралцсан байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны  
10 дугаар сарын 15-ны өдрийн  
А/656 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

**АНГЛИ ХЭЛНИЙ БАГШ, АХЛАХ АНГИЙН СУРАГЧДЫН АНГЛИ ХЭЛНИЙ  
ТҮВШИНГ АХИУЛАХ, ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫН ТӨСӨВ**

д/д	Бараа, материалын нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	2	3	4	5
1.	Англи хэлний багш нар, ахлах ангийн сурагчдын өдрийн хоолны зардал	109 хүн/5 өдөр	12,000	6,540,000
<b>Нийт</b>			<b>6,540,000</b>	